

Хувилбар No	2.0	Хүчинтэй хугацаа	2024-02-26
-------------	-----	------------------	------------

Тэнгэр Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн  
2024 оны 02 сарын 26-ны өдрийн  
BR 24/012 тогтоолын хавсралт №1



**ТЭНГЭР ДААТГАЛ ХХК-ИЙН МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ  
САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Домэйн:	ТУЗ
Эзэмшигч:	ТУЗ
Баримт бичиг баталсан:	ТУЗ
Хувилбар #:	2.0
Хүчинтэй хугацаа:	2024-02-26
Шийдвэр # (хэрэв байгаа бол)	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол BR 24/012

**Засварын түүх**

Доорх Засварын Түүхийн хүснэгтэд энэхүү баримт бичиг хэрэглэгдэж буй хугацаанд орсон бүх засварыг тэмдэглэнэ. Шинэчлэлтийг хийсэн огноо, хувилбарын дугаар, хийгдсэн өөрчлөлтүүдийн тайлбар, шалтгааны товч тайлбар, шинэчилсэн болон баталсан хүний нэр зэргийг хянах.

Хүчинтэй хугацаа	Шийдвэр # (хэрэв байгаа бол)	Хувилбар #	Өөрчлөлт Тайлбар / Шалтгаан	Үүсгэсэн / шинэчилсэн	Батлагдсан
			Шинэчлэн баталсан		
2024.02.26	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол BR 24/012	2.0	Шинэчлэн баталсан	ХХНМ Т.Батмагнай	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол

<b>АГУУЛГА</b>	
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	4
ХОЁРДУГААР БҮЛЭГ. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ .....	7
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ, .....	8
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ ТОГТООХ.....	12
ТАВДУГААР БҮЛЭГ. ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ ЭТГЭЭДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ, МЭДЭЭЛЭХ,.....	14
ТЭДГЭЭРИЙН ГҮЙЛГЭЭГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ.....	14
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. СЭЖИГТЭЙ БОЛОН ӨНДӨР ДҮНТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ .....	15
ТАЙЛАН .....	15
ХҮРГҮҮЛЭХ.....	15
ДОЛООДУГААР БҮЛЭГ. ХАРИЛЦАГЧИЙН ГҮЙЛГЭЭ,.....	16
ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЛИЙГ НУУЦЛАХ, ХАДГАЛАХ .....	16
НАЙМДУГААР БҮЛЭГ. СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ.....	16
ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА.....	16

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1.1. Журмын зорилго**

Энэхүү журмын зорилго нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх (цаашид “МУТС” гэх)-ээс урьдчилан сэргийлэх Тэнгэр даатгал ХХК (цаашид “Компани” гэх)-ийн үйл ажиллагаанд удирдлага болгон баримтлах дүрэм, журам, зарчим, зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтооход оршино.

**1.2. Нэр томъёоны тодорхойлолт**

Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар хэрэглэж ойлгоно:

- 1.2.1. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль” (цаашид “МУТС-тэй тэмцэх тухай хууль” гэх) гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Монгол Улсын хууль болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан, эсвэл оронд нь баталсан Монгол Улсын аливаа хуулийг;
- 1.2.2. “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам” (цаашид “Монголбанкны журам” гэх) гэж Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан журмыг;
- 1.2.3. “Мөнгө угаах” гэж МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад заасныг;
- 1.2.4. “Терроризмыг санхүүжүүлэх” гэж МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад заасныг;
- 1.2.5. “Харилцагч” гэдэгт Компаниар үйлчлүүлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг ойлгох бөгөөд харилцагчийг дараах байдлаар ангилна. Үүнд:
  - 1.2.5.1. “Дотоод харилцагч” гэдэгт Компанийн хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, Гүйцэтгэх удирдлага, газар, хэлтэс, салбар, тооцооны төвийн захирал, ажилтан, зөвлөхөөр ажиллаж буй мэргэжилтэн, хөлсөөр ажиллаж байгаа болон дадлагажин ажиллаж буй ажилтнуудыг хамруулан ойлгоно;
  - 1.2.5.2. “Гадаад харилцагч” гэдэгт Компаниас үйлчилгээ авахыг хүссэн, авч байгаа, авсан иргэн, хуулийн этгээдийг хамруулан ойлгоно;
  - 1.2.5.3. “Гэрээт гүйцэтгэгч” гэдэгт Компанитай гэрээ байгуулан бараа үйлчилгээ бэлтгэн нийлүүлж байгаа болон ажил гүйцэтгэж

байгаа хувь хүн, хуулийн этгээд, тэдгээртэй адилтган тооцож болох бусад этгээдийг хамруулан ойлгоно.

- 1.2.6. “Харилцагчийг таньж мэдэх” гэж харилцагчийг таньж мэдэх, тодорхойлох, мэдээллийг шалган баталгаажуулах зорилгоор Монгол Улсын хууль тогтоомжоор хориглоогүй харилцагчийн тухай мэдээллийг харилцагчаас гаргуулж авах, олж авах, тухайн мэдээллийн үнэн зөвийг тогтоох зорилгоор албан ёсны эх сурвалж, бичиг баримт, мэдээ, мэдээллийн сан болон мэдээллийн бусад эх үүсвэрийг ашиглахыг;
- 1.2.7. “Санхүүгийн мэдээллийн алба” (цаашид “СМА” гэх) гэж МУТС-тэй тэмцэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Монголбанкны дэргэд ажиллах хараат бус, бие даасан байгууллагыг;
- 1.2.8. “Гүйлгээг түдгэлзүүлэх” гэж сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг шалгах зорилгоор СМА-аас гаргасан шийдвэрийн дагуу тухайн гүйлгээг түр зогсоохыг;
- 1.2.9. “Гүйлгээг түр саатуулах” гэж сэжигтэй гүйлгээ болон харилцагчийн мэдээллийг эрх бүхий этгээдэд хүргүүлж шийдвэр гартал түр хугацаагаар хүлээлгэхийг;
- 1.2.10. “Сэжигтэй гүйлгээ” гэж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн хөрөнгө, гүйлгээ болон гүйлгээ хийх оролдлогыг;
- 1.2.11. “Бэлэн мөнгөний гүйлгээ” гэж үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглан хийсэн гүйлгээг;
- 1.2.12. “Бэлэн бус мөнгөний гүйлгээ” гэж олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, инкасс, төлбөрийн карт, цахим төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр хийсэн гүйлгээг;
- 1.2.13. “Сэжигтэй гүйлгээний тайлан” гэж энэхүү журмын 1.2.10-д заасан сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг агуулсан Монголбанкнаас баталсан маягт, журмын дагуу СМА-нд хүргүүлэх мэдээлэл, тайлбар, баримт бичгийг;
- 1.2.14. “Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан” гэж энэхүү журмын 1.2.11-д заасан гүйлгээний (цаашид “Өндөр дүнтэй гүйлгээ” гэх) тухай мэдээллийг агуулсан, Монголбанкнаас баталсан маягт, журмын дагуу СМА-нд хүргүүлэх мэдээлэл, тайлбар, баримт бичгийг;

- 1.2.15. “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг хариуцсан мэргэжилтэн” (цаашид “Мэргэжилтэн” гэх) гэж МУТС-тэй тэмцэх тухай хууль тогтоомж болон Компанийн бодлого, журам, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, тухайлбал өндөр дүнтэй гүйлгээ, сэжигтэй гүйлгээ болон гадаад төлбөр тооцооны өдөр тутмын хяналт, тайлагналыг гүйцэтгэх Компанийн ажилтныг;
- 1.2.16. “Улс төрд нөлөө бүхий этгээд” гэж МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 3.1.5<sup>1</sup> болон Монголбанкны журмын 7.2-т заасан этгээд, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, хамаарал бүхий этгээд<sup>3</sup>, нэгдмэл сонирхолтой этгээд<sup>4</sup> болон тэдгээрт хувийн болон бусад байдлаар шууд нөлөөлөх чадвартай эсхүл шууд нөлөөлөлд байгаа этгээдийг;
- 1.2.17. “Эцсийн өмчлөгч” гэж энэхүү журмын 4-р бүрэгт заасны дагуу тодорхойлогдох хүнийг;
- 1.2.18. “Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа” гэж харилцагчийг сайтар танин мэдэх боломжийг Компанид олгоход чиглэсэн үйл ажиллагаа буюу харилцагчийг тодорхойлох, мэдээллийг баталгаажуулахын тулд тухайн харилцагч, түүнтэй холбоотой этгээд болон санал болгож буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл цуглуулах, баримтжуулах, нягтлан шалгах, улмаар шалгалтын үр дүнд дүн шинжилгээ хийж, тухайн мэдээлэл үнэн бодит эсэхийг баталгаажуулах үйл ажиллагааг хэлнэ;
- 1.2.19. “Харилцагчийг нарийвчлан таньж мэдэх үйл ажиллагаа” гэж харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд илэрсэн өндөр эрсдэлтэй нөхцөл байдлыг сайтар ойлгох боломж олгоход чиглэсэн үйл ажиллагаа буюу тухайн харилцагчийн зорилго, нөхцөл байдлыг судалж, зөрүүтэй мэдээллийг баталгаажуулах, няцаах, эргэлзээтэй зүйлийг тодруулах зорилгоор харилцагчийн талаар нэмэлт мэдээлэл цуглуулж, баримтжуулах үйл ажиллагааг хэлнэ.
- 1.3. Компани нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэхтэй холбоотой харилцаанд энэхүү журмаас гадна МУТС-тэй тэмцэх тухай Монгол Улсын хууль, холбогдох бусад хууль

<sup>1</sup> МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 3.1.5-д заасны дагуу “улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг хэлнэ.

<sup>3</sup> Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5-д заасан тухайн улс төрд нөлөө бүхий этгээдийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хүүхэд, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг хэлнэ.

<sup>4</sup> Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.6-д заасан тухайн улс төрд нөлөө бүхий этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.

тогтоомжийг мөрдөх бөгөөд уг журмын зохицуулалт хууль тогтоомжтой зөрчилдсөн тохиолдолд хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

**1.4. Журмыг батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах**

Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, шинэчлэн найруулах тохиолдолд Гүйцэтгэх захирал тушаал гарган батална.

**1.5. Журмын үйлчлэх цар хүрээ**

Энэхүү журам нь Компанийн гадаад болон дотоод үйл ажиллагаанд нэгэн адил үйлчилнэ.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ  
ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**2.1. Компани нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална. Үүнд:**

2.1.1. Нэргүй, тоогоор илэрхийлсэн болон нууц буюу хуурамч нэрээр даатгалын гэрээ байгуулах хүсэлт гаргасан харилцагчид үйлчилгээ үзүүлэхгүй байх, тийм боломж олгосон үйлчилгээг харилцагчиддаа санал болгохгүй байх;

2.1.2. Олон улсын Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) болон Нэгдсэн Үндэсний Байгууллагаас террорист гэж зарлагдсан улс орон, байгууллага, этгээдүүдэд мөн Европын Холбоо, Франц Улс гаргасан нийтээр хүлээн зөвшөөрсөн хориглох болон анхаарах жагсаалтад орсон улс орон, байгууллага, этгээдүүдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэхгүй байх ба шаардлагатай тохиолдолд Мэргэжилтэнд хандах;

2.1.3. Энэхүү журмын 2.1.2-т зааснаас бусад улс орны эрх бүхий байгууллагаас гаргасан болон Компанийн дотоодын хориглох болон анхаарах жагсаалтад орсон улс орон, байгууллага, этгээдүүдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэхгүй байх ба шаардлагатай тохиолдолд Мэргэжилтэнд хандах;

2.1.4. Компанийн ажилтан бүр нь мөнгө угаах болох терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажиллагааны талаар мэдлэгтэй байх, Компани буюу түүний холбогдох ажилтнууд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх явдалтай тэмцэх олон улсын үйл ажиллагааны шаардлага хангасан байх;

**2.2. Компани нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Мэргэжилтэнтэй байх бөгөөд мэргэжилтнийг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилж, чөлөөлнө.**

Хувилбар No	2.0	Хүчинтэй хугацаа	2024-02-26
-------------	-----	------------------	------------

2.3. Мэргэжилтэн нь ажил үүргээ биелүүлэхэд мэдлэг, чадварын хувьд бэлтгэгдсэн, залилан, луйвар, мөнгө угаах, бусад төрлийн санхүүгийн гэмт хэрэг үйлдэж ял шийтгэл эдэлж байгаагүй, ашиг сонирхлыг зөрчилгүй байх шаардлагыг хангасан байна.

2.4. Мэргэжилтэн нь дараах үндсэн чиг үүрэгтэй:

2.4.1. МУТС-тэй тэмцэх төлөвлөгөө, бодлогын хэрэгжилтэд өдөр тутмын хяналт тавих, Компанийн бусад нэгж, албыг энэхүү асуудлаар мэргэжлийн удирдлага, зөвлөгөөгөөр хангах ажлыг зохион байгуулах;

2.4.2. МУТС-тэй тэмцэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой ажлыг удирдан зохион байгуулах, МУТС-тэй тэмцэх төлөвлөгөө, бодлого тодорхойлох, нэгдсэн удирдлагаар хангах зэрэг бодлогын түвшний ажлыг зохион байгуулах;

2.4.3. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд компанийн бүх салбар, нэгжээс харилцагч, данс, гүйлгээтэй холбогдох бүх баримт бичиг, мэдээллийг бүрэн гаргуулан авах, нэвтрэх эрхтэй байх бөгөөд мэдээллийг мэдээллийн санд үнэн зөв оруулах, мөн тэдгээрт тогтмол шинэчлэл хийж хэвшүүлэх үйл ажиллагаанд бусад газар, нэгжийг удирдлагаар хангаж, хяналт тавин ажиллах;

2.4.4. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний журам, заавар боловсруулах үе шатанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлж, санал боловсруулах;

2.4.5. Дараах агуулгыг тусгасан тайланг өөрийн гүйцэтгэх удирдлагад тогтмол танилцуулна:

2.4.5.1. Илрүүлсэн бүх сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл болон үр дагаврын тухай мэдээлэл;

2.4.5.2. Компанийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод бодлого, журам, хяналтын тогтолцоог сайжруулахтай холбогдуулан авсан арга хэмжээ, дотоод аудитын нэгжийн шалгалтын тайлан;

2.4.5.3. Эрх бүхий хяналт шалгалтын байгууллагаас болон Санхүү мэдээллийн албанаас хийсэн хяналт шалгалтын үр дүн;

2.4.5.4. Хяналт шалгалтаар Компанид өгсөн үүрэг даалгавар, засаж залруулах шаардлагатай арга хэмжээний талаарх мэдээлэл.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ,  
ТҮҮНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ШАЛГАХ**



### 3.1. Харилцагчийг таньж мэдэх журам

3.1.1. Харилцагчийг таньж мэдэх нь ажил хэргийн харилцааны гол үндэс бөгөөд Компанийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүхий л үйл ажиллагаанд хамаарна.

3.1.2. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны түвшин, цар хүрээ нь харилцагчийн төрөл, санал болгож буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, газар зүйн хүчин зүйлс (тухайн харилцагчийн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг улс орон, байнгын оршин суугч бус байх зэрэг), харилцагчийн онцлог байдал (үйл ажиллагааны төрөл, мэргэжил), санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх арга хэрэгсэл (зуучлагчаар дамжих буюу дамжихгүй байх) эсвэл холбогдох хууль тогтоомжийн дагуу Компаниас тогтоож болох бусад шалгуур үзүүлэлтээс хамааран харилцан адилгүй байна.

### 3.2. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа

3.2.1. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа нь тухайн харилцагч болон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл цуглуулах, баримтжуулах, харилцагчийн эрсдэлийн түвшинг үнэлэн тодорхойлох үйл ажиллагааг хууль тогтоожид заасан шаардлагын дагуу хийж гүйцэтгэхэд оршино.

3.2.2. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа дараах боломжийг олгоно:

3.2.2.1. Харилцагчийг хэн болохыг тодорхойлох буюу түүний эрхэлж буй үйл ажиллагаа, үйл ажиллагааны цар хүрээ, төрөл, үйл ажиллагаагаа идэвхитэй явуулж буй газар, удирдан явуулах арга хэлбэрийг ойлгох;

3.2.2.2. Харилцагчийн эд хөрөнгийн хэмжээ, санхүүгийн түүх, даатгалын төрөл, эд хөрөнгийн шинж чанарын талаар мэдээлэл олж авах;

3.2.2.3. Харилцааны эцсийн зорилгыг таних ба харилцагчийн хэрэглэдэг даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар ерөнхий ойлголттой болох.

3.2.3. Компанийн ажилтан нь харилцагчидтай даатгалын гэрээ байгуулах, даатгалын үйлчилгээ үзүүлэх зэрэг доор дурдсан аливаа бизнесийн харилцаа тогтоох, үйлчилгээ үзүүлэхийн өмнө харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүрэгтэй. Тухайлбал:

3.2.3.1. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, бизнесийн харилцаа үүсгэхийн өмнө;

Хувилбар No	2.0	Хүчинтэй хугацаа	2024-02-26
-------------	-----	------------------	------------

- 3.2.3.2. Санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээд тохиолдлын чанартайгаар 20,000,000 (хорин сая) төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;
  - 3.2.3.3. Харилцагчийн 24 цагийн дотор хийсэн, хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь 20,000,000 (хорин сая) төгрөгөөс бага боловч нийт үнийн дүн нь 20,000,000 (хорин сая) төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бол;
  - 3.2.3.4. Харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгах шаардлагатай байгаа бол;
  - 3.2.3.5. Гадаад төлбөр тооцооны гүйлгээ хийхийн өмнө;
  - 3.2.3.6. Тухайн харилцагч болон тухайн гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэх үндэслэл байгаа бол.
- 3.2.4. Энэхүү журмын 3.2.3-т заасны дагуу харилцагчийг таньж мэдэх зорилгоор дараах мэдээллийг харилцагчаас гаргуулж авна. Үүнд:
- 3.2.4.1. Харилцагч иргэний хувьд түүний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, иргэний үнэмлэхийн, эсхүл гадаад паспортын хуулбар, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргуулж авах;
  - 3.2.4.2. Харилцагч хуулийн этгээдийн хувьд түүний нэр, оршин байгаа газрын хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга, эцсийн өмчлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэрийг гаргуулж авах бөгөөд харилцагчийн өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхтэй холбоотой боломжит бүх арга хэмжээг авах;
  - 3.2.4.3. Эцсийн өмчлөгчийн нэрийн өмнөөс санхүүгийн үйлчилгээ авч байгаа эсэхийг мэдэх, ойлгох зорилгоор тухайн бизнесийн харилцааны зорилго, гүйлгээний утга, эцсийн хүлээн авагчийн тухай мэдээллийг тодруулах;
  - 3.2.4.4. Харилцагч нь хуулийн этгээд, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч бол түүний нэрийн өмнөөс харилцах этгээд нь тийм эрхтэй эсэхийг нягтлан уг этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, баримт бичигтэй нь тулгаж шалгах;
  - 3.2.4.5. Шилжүүлэг хийгч, хүлээн авагчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа газрын хаяг, харилцах утасны дугаар, дансны дугаарыг тодруулах;
  - 3.2.4.6. Харилцагч нь гэрээ хэлцлийг төлөөлж байгаа бол гүйлгээ эсхүл бизнесийн харилцаанд орж буй хөрөнгийн эцсийн өмчлөгчийг тодорхой болох хүртэл мэдээллийг гаргуулан авах бөгөөд хэрвээ

эцсийн өмчлөгч тогтоох боломжгүй өмчлөлийн бүтэцтэй бол шийдвэр гаргаж байгаа, харилцагчийн үйлдлийг удирдан чиглүүлж байгаа хувь хүн тодорхой болох хүртэл өмчлөлийн шатлал тус бүр дэх хяналтын бүтцийг тодорхойлох улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний үнэмлэх зэрэг шаардлагатай баримт бичгүүдийг гаргуулан авна;

3.2.4.7. Даатгалын ашиг шимийг хүртэгч, эсхүл хүртэгчсэд /beneficiary(s)/ тодорхой болмогц тэдгээрийг таньж мэдэх дараах үйл ажиллагааг нэмэлтээр явуулах шаардлагатай:

3.2.4.7.1. ашиг шимийг хүртэх этгээд нь хувь хүн, хуулийн этгээд эсхүл гэрээ хэлцэл бол тэдгээрийн нэрийг тодорхой болгох;

3.2.4.7.2. ашиг шимийг хүртэгчийг тодорхой бүлэг /жишээлбэл хүүхдүүд, гэр бүлийн гэх мэт/ эсхүл шинж чанараар/хүсэлт гаргасан этгээд/ гэж тодорхойлсон тохиолдолд төлбөр хийх үед ашиг шимийг хүртэгчийг таньж мэдэж болохуйц хангалттай мэдээлэл олж авах;

3.2.4.7.3. дээр дурдсан 3.2.4.7.1 болон 3.2.4.7.2 дахь тохиолдолд хоёуланд нь төлбөр хийх үедээ ашиг шимийг хүртэгчийн хувьд харилцагчийг таньж, мэдэх үйл ажиллагааг явуулна.

3.3. Компани нь 3.2.4-т заасан мэдээллийг харилцагчаас гаргуулан авахдаа энэхүү журмын хувь хүн бол Хавсралт 2, хуулийн этгээд бол Хавсралт 3, хуулийн этгээдийг төлөөлж байгаа бол Хавсралт 4-т заасан мэдээлэл, баримт бичгийг тулган баталгаажуулна.

3.4. Харилцагчийн өгсөн мэдээлэл буруу, ташаа болох нь тогтоогдвол харилцагчаас энэ тухай тайлбар гаргуулах бөгөөд тайлбар өгөхөөс татгалзах, мэдээлэл нь хуурамч, үндэслэлгүй болон шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзвал харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзана.

3.5. Компани нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлсний үндсэн дээр харилцагчийн эрсдэлийн түвшинг үнэлж, өндөр эрсдэлтэй харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлно.

3.6. Компанийн хийсэн эрсдэлийн үнэлгээгээр болон Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн хэсэгт харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг нарийвчлан хийх бөгөөд дараах харилцагч, гүйлгээг өндөр эрсдэлтэйд хамааруулан үзнэ:

3.6.1. харилцагч нь улс төрд нөлөө бүхий этгээд бол;

3.6.2. харилцагч нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд бол;

- 3.6.3. харилцагч нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд бол;
- 3.6.4. огцом өөрчлөгдсөн их дүнтэй гүйлгээ бол;
- 3.6.5. эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй гүйлгээ бол;
- 3.6.6. улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийсэн гүйлгээ бол;
- 3.6.7. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсаар дамжуулан хийсэн гүйлгээ бол;
- 3.6.8. цахим шилжүүлэгт үндэслэн хийгдэж байгаа гүйлгээ болон харилцагчийн эцсийн өмчлөгч нь улс төрд нөлөө бүхий этгээд байгаа бол;
- 3.6.9. эрх бүхий хяналт, зохицуулалтын байгууллага, СМА-с эсхүл ФАТФ, ФАТФ-ын бүс нутгийн байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй гэж тодорхойлогдсон улс орон, бүс нутагтай холбоотой гүйлгээ бол;
- 3.6.10. харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр дамжуулан хийсэн эсхүл зайнаас бизнесийн харилцаа үүсгэсэн харилцагчийн гүйлгээг.
- 3.7. Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг өндөр эрсдэлтэй харилцагчид бүтээгдэхүүн, үйлчилгээ авах бүрт нь холбогдох нэмэлт мэдээллийг авах, өмнө нь өгсөн мэдээлэлд гарсан өөрчлөлтийг тусгах замаар байнгын үргэлжлэх хэлбэрээр хэрэгжүүлнэ.
- 3.8. Мэргэжилтэн нь харилцагчийг таньж мэдэх чиг үүргийнхээ хүрээнд өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн харилцагчдад цаашид үйлчилгээ үзүүлэхгүй байх асуудлыг Гүйцэтгэх удирдлагын зөвшөөрлийг авч гүйцэтгэнэ.
- 3.9. Компани нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан мэдээлэлд байнгын хяналт тавьж, өөрчлөлт орсон тухай бүрд мэдээллийг шинэчлэн, харилцагчийн болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг бизнесийн харилцааны туршид цуглуулж, хадгална. Дараах тохиолдолд харилцагчийн мэдээллийг дахин тулгаж шалгана:
- 3.9.1. Өндөр дүнтэй санхүүгийн үйлчилгээ авах гэж байгаа тохиолдолд;
- 3.9.2. Авч байсан санхүүгийн үйлчилгээнд өөрчлөлт гарсан тохиолдолд;
- 3.9.3. Өмнө нь авсан харилцагчийн мэдээлэл нь санхүүгийн харилцаа болон гүйлгээний шинж чанар, зорилгыг ойлгож тодорхойлоход хангалтгүй байвал.

#### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ ТОГТООХ

- 4.1. Компани нь харилцагч өөрийгөө эсхүл нэг болон түүнээс дээш эцсийн өмчлөгчийг төлөөлж байгаа эсэхийг тодорхойлж, эцсийн өмчлөгчийг таньж мэдэх шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь эцсийн

өмчлөгч, харилцагчийн эзэмшилд байгаа хөрөнгийн ашиг шимийг хүртэгч этгээд, гэрээ хэлцлийн дагуу хөрөнгийн хөрөнгөө шилжүүлэн, шийдвэр гарган удирддаг эсхүл ашиг шимийг хүртэгч этгээдийг тодорхойлох боломжит бүх арга хэмжээг авах бөгөөд эцсийн өмчлөгчийг тогтоосон гэж үзэх хүртлээ найдвартай эх сурвалжаас шаардлагатай мэдээллийг авч ашиглана.

- 4.2. Хувьцаа эзэмшигчдийн мэдээллээ ил тод байлгах үүрэг хүлээсэн хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд (хуулийн этгээд эсхүл эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд), мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй хяналт шалгалт хийгддэг гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаа эзэмшигчдийн мэдээллээ ил тод байлгах үүрэг хүлээсэн хувьцаат компаниудын тухайд энэхүү журмын Хавсралт 2, 3, 4-д дурдсан мэдээллийг авах бөгөөд харилцагчийг тодорхойлох нэмэлт мэдээлэл шаардахгүй байж болно.
- 4.3. Эцсийн өмчлөгчийг тогтоохдоо Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4<sup>1</sup> дүгээр зүйлд заасан дараах дарааллыг баримтална:
- 4.3.1. хувьцааны дийлэнх хэсэг буюу нийт хувьцаа 33 хувийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүнийг;
- 4.3.2. энэ журмын 4.3.1-д заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж байгаа, эсхүл өөрийн эрхээ бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хүнийг;
- 4.3.3. энэ журмын 4.3.1, 4.3.2-т заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэгч хүнийг.
- 4.4. Хөрөнгийг удирдах хэлцэл болон эрх зүйн зохицуулалт бүхий этгээдийн хувьд эцсийн өмчлөгчийг тодорхойлох боломжит бүх арга хэмжээг авахдаа дараах мэдээллийг авна:
- 4.4.1. хөрөнгийг гэрээний дагуу шилжүүлж байгаа этгээд /Settlor/;
- 4.4.2. Траст гэрээгээр хөрөнгийг захиран зарцуулах байгаа этгээд эсхүл хэд хэдэн этгээд /Trustee(s)/;
- 4.4.3. Траст гэрээний ашиг шимийг хүртэгч /beneficiary(s)/;
- 4.4.4. хэрвээ байгаа бол гэрээний ашиг шимийг хүртэгчийг хамгаалах "protector"-ын мэдээллийг гаргуулан авна;
- 4.4.5. Дээрхээс өөр төрлийн гэрээ хэлцлийн хувьд дээрхтэй ижил байр суурин дээр байгаа хувь хүмүүсийг тогтоох үйл ажиллагааг хийнэ.
- 4.5. Шууд бус өмчлөлийг тогтоохдоо:
- 4.5.1. бүх төрлийн хуулийн этгээд эсхүл трастын гэрээ болон ижил төстэй гэрээ хэлцлээр эзэмшиж байгаа хувьцааны хувийг тэдгээрийн хувьцаа эзэмшигч эсхүл ашиг шимийг хүртэгч этгээд /бүлэг этгээдүүдийн/ хувьцаа гэж тооцно;
- 4.5.2. Гэр бүлийн нэг гишүүний эзэмшиж байгаа хувийг гэр бүлийн бусад гишүүдийн эзэмшиж байгаа хувьтай нэгтгэн бүхэлд нь авч үзнэ.

Хувилбар No	2.0	Хүчинтэй хугацаа	2024-02-26
-------------	-----	------------------	------------

**ТАВДУГААР БҮЛЭГ. ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ ЭТГЭЭДИЙН ТАЛААРХ  
МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ, МЭДЭЭЛЭХ, ТЭДГЭЭРИЙН ГҮЙЛГЭЭГ  
ТҮДГЭЛЗҮҮЛЭХ**

- 5.1. ~~Компани нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан мэдээллийн санг бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах бөгөөд Мэргэжилтэн, энэхүү мэдээллийн сангийн бүрэн бүтэн байдал, мэдээллийн шинэчлэлд хяналт тавьж ажиллана.~~
- 5.2. Компанийн гүйлгээ, гүйлгээний хяналт, баталгаажуулалт хариуцсан ажилтан бүх төрлийн гүйлгээний хувьд тухайн гүйлгээнд оролцогч талуудын нэр нь энэхүү журмын 2.1.2-т заасан жагсаалтад орсон нэртэй тохирч байгаа эсэхийг тогтмол хяналт тавьж ажиллана. Хэрэв шилжүүлэгч, гуйвуулагч эсвэл хүлээн авагчийн нэр нь жагсаалтад дурдагдсан нэртэй тохирч байвал тухайн гүйлгээг түр саатуулж, Мэргэжилтэнд нэн даруй утсаар мэдэгдэнэ.
- 5.3. Мэргэжилтэн нь Компанийн ажилтнаас ирүүлсэн мэдээллийг шалгаж, хэрэв тухайн харилцагчийн нэр нь энэхүү журмын 2.1.2-т заасан жагсаалтад орсон нэртэй тохирч байгаа нь батлагдвал гүйлгээ, эзэмших данс болон холбогдох хөрөнгийн гүйлгээний хөдөлгөөнийг шууд зогсоох, гүйлгээ хийх эрхгүй болгох талаар Компанийн ажилтанд мэдээлнэ.
- 5.4. Мэргэжилтэн нь 5.3-т дурдсан нөхцөл байдал, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх бүх мэдээллийг СМА болон Тагнуулын байгууллагад нэн даруй мэдээлж, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгийн тайлангын мэдээллийг зохих журмын дагуу 24 цагийн дотор Тагнуулын байгууллага болон СМА-д хүргүүлнэ. Хэрэв харилцагч нь жагсаалтад дурдагдсан нэртэй тохирохгүй буюу гүйлгээг сэжигтэй гэж тооцох үндэслэл байхгүй гэж үзвэл Мэргэжилтэн нь тухайн гүйлгээг хийж гүйцэтгэх үүргийг 1 цагийн дотор Компанийн ажилтанд өгнө.
- 5.5. Мэргэжилтэн нь Компанийн ажилтнаас ирүүлсэн мэдээллийг шалгаж, хэрэв тухайн харилцагчийн нэр нь 2.1.2-д заасан жагсаалтад орсон нэртэй тохирч байгаа нь батлагдвал гүйлгээ, эзэмших данс болон холбогдох гүйлгээнд оролцогч талуудын талаарх бүх мэдээллийг ажлын 1 /нэг/ өдрийн дотор СМА-нд зохих журмын дагуу хүргүүлнэ. Хэрэв харилцагч нь 2.1.3-д заасан жагсаалтад дурдагдсан нэртэй тохирохгүй буюу гүйлгээг сэжигтэй гэж тооцох үндэслэл байхгүй гэж үзвэл Мэргэжилтэн нь тухайн гүйлгээг хийж гүйцэтгэх үүргийг 1 цагийн дотор Компанийн ажилтанд өгнө.
- 5.6. СМА-наас гүйлгээг түдгэлзүүлэх шийдвэр ирсэн тохиолдолд Мэргэжилтэн нь холбогдох Компанийн ажилтанд 1 цагийн дотор хүргүүлнэ.
- 5.7. Түдгэлзүүлсэн гүйлгээтэй холбоотой харилцагчийн талаарх болон бусад шаардлагатай мэдээллийг тодруулан шалгасны дүнд СМА-наас өгсөн

шийдвэрийн дагуу Мэргэжилтэн шаардлагатай арга хэмжээг авч, холбогдох Төв албаны нэгж, салбарыг мэдээллээр хангаж ажиллана.

- 5.8. Энэхүү журмын 5.2-д заасны дагуу утсаар мэдэгдсэн Компанийн ажилтан Сэжигтэй гүйлгээний тайлан /Тэнгэр даатгал ХХК Маягт 01/-г бөглөж Мэргэжилтэнд ажлын нэг өдрийн дотор хүргүүлнэ.

### **ЗУРГААДУГААР БҮЛЭГ. СЭЖИГТЭЙ БОЛОН ӨНДӨР ДҮНТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН ХҮРГҮҮЛЭХ**

- 6.1. Мэргэжилтэн нь 20,000,000 (хорин сая) төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний, гадаад төлбөр тооцооны гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор эдгээр гүйлгээний тухай мэдээллийг батлагдсан маягт, журмын дагуу СМА-д хүргүүлнэ.
- 6.2. Хэрэв энэ журмын 6.1-д заасан гүйлгээ мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой байсан гэж үзэх үндэслэл байгаа бол 24 цагийн дотор СМА-д сэжигтэй гүйлгээний тайланг хүргүүлнэ.
- 6.3. Харилцагч нь Компанид худал эсхүл хуурамч бичиг баримт, мэдээлэл өгсөн бол СМА-д сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэх бөгөөд сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэхэд ямар нэгэн хязгаарлалт, үнийн дүн хамаарахгүй.
- 6.4. СМА-д хүргүүлэх тайланг факс, цахим хэлбэрээр, эсхүл бичгээр хүргүүлэх бөгөөд СМА-н баталсан маягтын дагуу хүргүүлнэ.
- 6.5. СМА-д хүргүүлэх сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл дараах агуулгатай байна:
- 6.5.1. Компанийн нэр, хаяг болон мэдээлэл хүргүүлсэн албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
- 6.5.2. Харилцагч, хүлээн авагчийн талаарх мэдээлэл;
- 6.5.3. Тухайн гүйлгээний утга, үнийн дүн, гүйцэтгэсэн хэлбэр, огноо, дансны дугаар, гүйлгээнд оролцогчид болон данс эзэмшигчийн талаарх мэдээлэл;
- 6.5.4. Тухайн гүйлгээг сэжиглэх болсон үндэслэл, нөхцөл байдлын тухай товч тайлбар;
- 6.5.5. Холбогдох бусад баримт бичиг.
- 6.6. Эрх бүхий байгууллага бичгээр хүсэлт ирүүлсэн бол Монголбанкны Ерөнхийлөгч, Улсын ерөнхий прокурорын хамтран баталсан мэдээлэл өгөх журмын дагуу тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын тухай мэдээллийг гаргаж өгнө.
- 6.7. Энэ журмын 6.5-д зааснаас бусад этгээдэд харилцагчийн гүйлгээний тухай мэдээлэл өгөх, дамжуулахыг хориглоно.

Хувилбар No	2.0	Хүчинтэй хугацаа	2024-02-26
-------------	-----	------------------	------------

**ДОЛООДУГААР БҮЛЭГ. ХАРИЛЦАГЧИЙН ГҮЙЛГЭЭ,  
ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЛИЙГ НУУЦЛАХ, ХАДГАЛАХ**

- 7.1 Энэхүү журмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор харилцагч болон гүйлгээний талаарх мэдээллийг нууцлах, нууцлалыг хангах үүргийг тухайн мэдээллийг бэлтгэсэн, хянасан, нэвтэрсэн, дамжуулсан Компанийн ажилтан бүр хүлээнэ.
- 7.2 Сэжигтэй гүйлгээний тайланг мэдээлсэн, түүнтэй танилцсан Компанийн ажилтанд дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:
- 7.2.1 Харилцагч болон түүний гүйлгээний талаар сэжигтэй гүйлгээний тайлан бэлтгэж Мэргэжилтэнд болон СМА-д мэдээлсэн, мэдээлэх гэж байгаа, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой шалгагдаж байгаа талаар тухайн гүйлгээг хийлгэсэн харилцагч болон эрх олгогдсон байгууллагын албан ёсоор томилогдсон албан тушаалтнаас өөр хувь хүн болон хуулийн этгээдэд мэдээлэх, мэдэгдэх;
- 7.2.2 СМА-наас түдгэлзүүлсэн гүйлгээний тухай хууль тогтоомжийн дагуу эрх олгогдсон байгууллагын албан ёсоор томилогдсон албан тушаалтнаас өөр хувь хүн болон хуулийн этгээдэд мэдээлэх, мэдэгдэх.
- 7.3 Сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг бэлтгэх, хүргүүлэх, гүйлгээг тусгайлан хянах, түдгэлзүүлэх тухай мэдээлэл, тэдгээрийн хуулбарыг нууцын тухай хууль тогтоомжийн дагуу чанд хадгална.
- 7.4 Харилцагчийн хийсэн гүйлгээ, данс болон харилцагчийн талаар олж авсан мэдээлэл, баримт бичгийг тухайн данс хаагдсан, эсхүл гүйлгээ хийгдсэнээс хойш 5-аас доошгүй жилийн хугацаанд хадгална.

**НАЙМДУГААР БҮЛЭГ. СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ**

- 8.1. Компани нь МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааны талаар жил бүр нэгээс доошгүй удаа сургалт зохион байгуулна.
- 8.2. Мэргэжилтэн нь сургалтанд хэрэглэсэн материалыг хадгална.
- 8.3. Мэргэжилтэн нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэхтэй холбоотой шинэ мэдээ, мэдээллийг холбогдох ажилтнуудад тогтмол хүргэж байна.
- 8.4. Компанийн ажилтан бүр Мэргэжилтний хүргүүлсэн мэдээллийн дагуу зохих арга хэмжээг авч, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА**



Хувилбар No	2.0	Хүчинтэй хугацаа	2024-02-26
-------------	-----	------------------	------------

9.1 Энэхүү журмын хэрэгжилтэд Гүйцэтгэх захирал болон Мэргэжилтэн хяналт тавьж ажиллана.

9.2 Компанийн ажилтан энэхүү журмыг зөрчсөн нь Хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн гэж тооцогдох буюу сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

-----oOo-----

Хувилбар No

2.0

Хүчинтэй хугацаа

2024-02-26

Хавсралт 1

**Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааны маягт**

Харилцагч	Харилцагчийн бизнесийн түнш
<p>Компанийн харилцагчийн танилцуулга. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Компанийн нэр</li> <li>▪ Бүртгэлийн дугаар/огноо</li> <li>▪ Өмчлөгч/Эцсийн өмчлөгч</li> <li>▪ Харьяалал (орон)</li> <li>▪ Бизнесийн төрөл</li> <li>▪ Зээлийн үлдэгдэл</li> <li>▪ Валют</li> </ul>	<p>Харилцагчийн бизнесийн түншийн танилцуулга. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Компанийн нэр</li> <li>▪ Бүртгэлийн дугаар/огноо</li> <li>▪ Өмчлөгч/Эцсийн өмчлөгч</li> <li>▪ Харьяалал (орон)</li> <li>▪ Бизнесийн төрөл</li> <li>▪ Зээлийн үлдэгдэл</li> </ul>
Санхүүгийн арилжаа/гүйлгээ	Үндсэн арилжаа
<p>Хийх гэж буй арилжаа/гүйлгээ:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Хэмжээ (балансын болон балансын гадуур)</li> <li>▪ Даатгалын бүтээгдэхүүн</li> <li>▪ Арилжаа/гүйлгээний ашиг</li> <li>▪ Барьцаа</li> <li>▪ Хугацаа</li> </ul> <p>Хийх гэж буй арилжаа/гүйлгээнд дараах талууд оролцох эсэхийг тодруулна уу:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ АНУ-аас тусгайлан хориглосон этгээд</li> <li>▪ АНУ-ын банкаар дамжих эсэх</li> </ul> <p>АНУ-аас гаралтай хөрөнгийг ашиглах буюу АНУ-ын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх бол тэмдэглэнэ үү.</p>	<p>Санхүүжүүлэх бизнесийн арилжаа:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Бүтээгдэхүүн</li> <li>▪ Тээвэрлэлт</li> <li>▪ Хэмжээ</li> <li>▪ Зуучлагч/нийлүүлэгч</li> </ul> <p>Хийх гэж буй арилжаа/гүйлгээнд дараах талууд оролцох эсэхийг тодруулна уу:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ АНУ-аас тусгайлан хориглосон этгээд</li> <li>▪ Хар жагсаалтад орсон буюу өндөр эрсдэлтэй орон</li> <li>▪ АНУ-аас хориглосон бүтээгдэхүүн</li> </ul> <p>АНУ-ын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх бол тэмдэглэнэ үү.</p>
Харилцагчийн бизнесийн танилцуулга	Хянан нийцүүлэлтийн асуудлууд
<p>Харилцагчийн бизнесийн бүртгэл. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Харилцагч болсон огноо</li> <li>▪ Даатгалтай холбоотой гарсан асуудлууд</li> <li>▪ Даатгалын харилцаа (бусад даатгалын компаниуд)</li> </ul>	<p>Анхаарал татсан асуудлуудыг тэмдэглэнэ үү:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Гүйлгээг түдгэлзүүлж байсан эсэх</li> <li>▪ Гүйлгээний талаар сэжигтэй гүйлгээний тайлан хүргүүлж байсан эсэх</li> <li>▪ Данс/хөрөнгийг хөлдөөж байсан эсэх</li> </ul>

Хувилбар No	2.0	Хүчинтэй хугацаа	2024-02-26
-------------	-----	------------------	------------

	<ul style="list-style-type: none"> <li>▪ Зөрчлийн шалгалт хийгдэж байсан эсэх, үр дүн</li> <li>▪ Хуулийн зөрчил, маргаан, шүүхийн хэрэг байгаа эсэх</li> <li>▪ Авлигын хэрэгт холбогдож байсан эсэх</li> <li>▪ Хориотой бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх буюу борлуулах үйл ажиллагаа явуулж байсан эсэх</li> <li>▪ Өндөр эрсдэлтэй оронтой бизнесийн харилцаатай эсэх</li> </ul> <p>Дээрх зүйлийг харилцагч болон түүний түнш тус бүрээр шалгаж тогтооно.</p>
--	---

**Боловсруулсан:**

**Гарын үсэг:**

**Огноо:**

### ENHANCED DUE DILIGENCE FORM

Customer	Business partner of customer
<p>Please provide details on the bank's customer.</p> <p>These should include:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Company name</li> <li>▪ Registration number / date</li> <li>▪ Owner / Ultimate Beneficiary</li> <li>▪ Residence (Country)</li> <li>▪ Business model</li> <li>▪ Current debt</li> <li>▪ Currency</li> </ul>	<p>Please provide details on the customer's business partner.</p> <p>These should include:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Company name</li> <li>▪ Registration number / date</li> <li>▪ Owner / Ultimate Beneficiary</li> <li>▪ Residence (Country)</li> <li>▪ Business model</li> <li>▪ Current debt</li> </ul>
Financial Transaction	Underlying transaction
<p>Please outline the intended transaction:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Volume (on-/off-balance)</li> <li>▪ Insurance-Product</li> <li>▪ Transaction – Profit</li> <li>▪ Collateral</li> <li>▪ Tenor</li> </ul>	<p>Please outline the underlying real-economy transaction:</p> <p>Ц</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Product</li> <li>▪ Logistics / Transport</li> <li>▪ Volume</li> <li>▪ Any involved agents/suppliers</li> </ul>

Хувилбар No	2.0	Хүчинтэй хугацаа	2024-02-26
-------------	-----	------------------	------------

<p>Please high-light, if financial transaction would</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Involve US designated persons / institutions</li> <li>▪ Require USD clearing</li> </ul>	<p>Please high-light, if the underlying transaction would involve</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ US designated persons / institutions</li> <li>▪ Sanctioned or high-risk countries</li> <li>▪ Products under sanctions (e.g. US sanctions)</li> </ul>
<p>Please high-light, if the financial transaction would require US based / originated funds and / or require transit through US territory</p>	<p>Please high-light, if transaction would pass through US territory.</p>
<p><b>Business track-record</b></p>	<p><b>Compliance Issues / Concerns</b></p>
<p>Please document the business track-record:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Customer since</li> <li>▪ Insurance claims, issues, if any</li> <li>▪ Insurance relations (other insurance companies)</li> </ul>	<p>Please high-light, if there were any issues or concerns:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Suspended transactions, if any</li> <li>▪ Reported transactions, if any</li> <li>▪ Frozen accounts / assets, if any</li> <li>▪ Investigations and results, if any</li> <li>▪ Legal incidents or court cases, if any</li> <li>▪ Involvement in corruption cases, if any</li> <li>▪ Dealings in restricted goods / products, if any</li> <li>▪ Business in or with high risk entities and / or countries</li> </ul> <p>This is applicable to both customer and business partner.</p>

**Prepared by:**

**Signed by:**

**Date:**



Харилцагч нь хувь хүн бол:

<b>Хүснэгт 1</b>	
<b>Харилцагчаас авах</b>	<b>Тулгаж шалгах бичиг баримт<sup>5</sup></b>
<b>мэдээлэл</b>	
Овог, эцэг/эх/-ийн нэр	Иргэний үнэмлэх эсхүл паспорт
Өөрийн нэр	Иргэний үнэмлэх эсхүл паспорт
Төрсөн огноо	Иргэний үнэмлэх эсхүл паспорт
Регистрийн дугаар	Иргэний үнэмлэх эсхүл паспорт
Байнгын оршин суудаг газрын хаяг, холбоо барих утасны дугаар	Энэ мэдээллийг харилцагчаас ямар хэлбэрээр гаргуулан авах, хэрхэн тулгаж шалгахыг мэдээлэх үүрэгтэй этгээд өөрийн дотоод бодлого журмаар зохицуулна.
Одоо оршин суугаа газрын хаяг, холбоо барих утасны дугаар	Энэ мэдээллийг харилцагчаас ямар хэлбэрээр гаргуулан авах, хэрхэн тулгаж шалгахыг мэдээлэх үүрэгтэй этгээд өөрийн дотоод бодлого журмаар зохицуулна.
Эрхэлж буй ажил, бизнес: 1. Бизнесийн чиглэл, цар хүрээг тодруулах 2. Ажлын газрын нэр, хаяг, албан тушаалыг тодруулах	Энэ мэдээллийг харилцагчаас ямар хэлбэрээр гаргуулан авах, хэрхэн тулгаж шалгахыг мэдээлэх үүрэгтэй этгээд өөрийн дотоод бодлого журмаар зохицуулна.
Өөр хэн нэг этгээдийг төлөөлөн данс нээлгэж, гүйлгээ хийж байгаа эсэхийг тодруулах.	А. Хэрэв харилцагч нь хэн нэгнийг төлөөлж байгаа бол төлөөлүүлэгч этгээдийн мэдээллийг авна. Төлөөлүүлэгч этгээд нь хувь хүн бол хүснэгт-1, хуулийн этгээд бол Хүснэгт 2, 3-т заасан мэдээллийг гаргуулан авч үнэн бодит эсэхийг нь тодорхойлж, мэдээллийг нь баталгаажуулах шаардлагатай. В. Хэрэв харилцагч нь хуулийн этгээд эсхүл гэрээ хэлцлийг төлөөлж байгаа бол Хүснэгт 2, 3-т заасан мэдээллийг гүйлгээ эсхүл бизнесийн харилцаанд орж буй хөрөнгийн эцсийн өмчлөгчийг тодорхой болох хүртэл гаргуулан авна. Хэрвээ эцсийн өмчлөгч тогтоох боломжгүй өмчлөлийн бүтэцтэй бол шийдвэр гаргаж байгаа, харилцагчийн үйлдлийг удирдан

<sup>5</sup> Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу тулгаж шалгасан бичиг баримтын хуулбарыг харилцагчийн хувийн хэрэгт хадгална.

Хувилбар No	2.0	Хүчинтэй хугацаа	2024-02-26
-------------	-----	------------------	------------

	<p>чиглүүлж байгаа хувь хүн тодорхой болох хүртэл гаргуулан авна. Харилцагчаас гаргуулан авсан мэдээллийн бодит байдлыг нотлох баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргуулан авч үнэн бодит байдлыг нь хянана.</p> <p>С. Хэрвээ харилцагч нь Траст гэрээгээр бизнесийн харилцаанд орж байгаа бол дараах этгээдийн мэдээллийг харилцагчаас гаргуулан авна. Үүнд: 1. хөрөнгөө траст гэрээний дагуу бусдад шилжүүлж байгаа этгээд/ Settlor/, 2. Траст гэрээгээр хөрөнгийг захиран зарцуулж байгаа этгээд эсхүл хэд хэдэн этгээд /Trustee(s)/, 3.Траст гэрээний ашиг шимийг хүртэгч /beneficiary(s)/ 4. хэрвээ байгаа бол гэрээний ашиг шимийг хүртэгчийг хамгаалах “protector”-ын мэдээллийг гаргуулан авна.</p> <p>5. Гэрээний ашиг шимийг хүртэгч нь хуулийн этгээд хэлбэртэй байгаа тохиолдолд уг хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг гаргуулан авна.</p> <p>D. Дээрхээс өөр төрлийн гэрээ хэлцлийн хувьд дээрхтэй ижил байр суурин дээр байгаа хувь хүмүүсийг тогтоох үйл ажиллагааг хийнэ.</p>
--	--



Харилцагч нь хуулийн этгээд бол:

<b>Хүснэгт 2</b>	
<b>Харилцагчаас мэдээлэл</b>	<b>Тулгаж шалгах бичиг баримт</b>
Нэр	Улсын бүртгэлийн гэрчилгээ
Улсын бүртгэлийн дугаар	Улсын бүртгэлийн гэрчилгээ
Регистрийн дугаар	Улсын бүртгэл, Санхүү болон татварын байгууллагаас олгосон баримт, бичиг
Хувьцаа эзэмшигчид	Улсын бүртгэлийн гэрчилгээ Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах баримт бичиг, шийдвэр, аж ахуйн нэгжийн дүрэм
Үйл ажиллагааны чиглэл	Улсын бүртгэлийн гэрчилгээ Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах баримт бичиг, шийдвэр, аж ахуйн нэгжийн дүрэм
Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшлийн бүтэц,	Өмчлөлийн бүтцийг харуулсан мэдээлэл, уг мэдээлэлд орсон хууль этгээд тус бүрийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар. /эдгээр бичиг баримтад хувьцаа эзэмшигчид нь тодорхой бичигдсэн байх шаардлагатай/ Эцсийн өмчлөгч тодорхой болох хүртэлх бүх хуулийн этгээдийг хамруулна.
Хуулийн этгээдийн удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга	Улсын бүртгэлд хуулийн этгээдийн бүртгүүлсэн баримт бичиг, уг бүртгэлтэй нийцтэй хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч эсхүл удирдах зөвлөлийн шийдвэр.
Үйл ажиллагаа явуулдаг хаяг, холбоо барих утасны дугаар	Энэ мэдээллийг ямар хэлбэрээр харилцагчаас гаргуулан авах, хэрхэн нягтлахыг мэдээлэх үүрэгтэй этгээд өөрийн дотоод бодлого журмаар зохицуулна.
Эцсийн өмчлөгчийн мэдээлэл	Хэрэв эцсийн өмчлөгч нь тухайн хуулийн этгээдэд ямар нэг албан тушаал эрхэлдэггүй бол Хүснэгт 1-ийн дагуу бүх мэдээллийг авах ба тухайн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч мөн болохыг нотлох баримтын хамт авна.

Хувилбар No	2.0	Хүчинтэй хугацаа	2024-02-26
-------------	-----	------------------	------------



Хувилбар No

2.0

Хүчинтэй хугацаа

2024-02-26



Харилцагч нь хуулийн этгээдийг төлөөлж байгаа бол:

<b>Хүснэгт 3</b>	
<b>Харилцагчаас авах мэдээлэл</b>	<b>Тулгаж шалгах бичиг баримт</b>
Хэрэв харилцагч нь хувь хүн бол Хүснэгт-1-т заасан мэдээллийг гаргуулан авна.	Хүснэгт-1-т заасан бичиг баримтууд
Хэрэв харилцагч нь хуулийн этгээд бол: Хүснэгт-2-ийн дагуу мэдээллийг гаргуулан авна	Хэрэв харилцагч нь хуулийн этгээд бол: Хүснэгт-2-т заасан бичиг баримтууд
Эрх зүйн гэрээгээр төлөөлж байгаа бол гэрээний талуудын Улсын бүртгэлийн мэдээлэл, тэр дундаа (i) гэрээнд заасан хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээдийн нэр, хаяг бусад бүртгэлийн мэдээллүүд; (ii) төлөөлөх эрхтэй этгээдийг томилох, чөлөөлөх эрх бүхий хувь хүн эсхүл хуулийн этгээдийн мэдээллүүд; (iii) хөрөнгийн ашгийг хүртэх эрхтэй этгээдийн мэдээлэл; (iv) хөрөнгөө траст гэрээний дагуу бусдад шилжүүлж байгаа этгээд /Settlor/, Траст гэрээгээр хөрөнгийг захиран зарцуулж байгаа этгээд эсхүл хэд хэдэн этгээд /Trustee(s)/, (v) Траст гэрээний ашиг шимийг хүртэгч /beneficiary(s)/, хэрвээ байгаа бол гэрээний ашиг шимийг хүртэгчийг хамгаалах "protector"-ын мэдээллийг гаргуулан авна; (vi) Гэрээний ашиг шимийг хүртэгч нь хуулийн этгээд хэлбэртэй байгаа тохиолдолд уг хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг гаргуулан авна.	Энд дурдсан гэрээний бүх талуудын мэдээллийг хувь хүн бол Хүснэгт 1 хуулийн этгээд бол Хүснэгт 2-ийн дагуу бүрдүүлж үнэн бодит байдлыг нь нягтална.